



СЭЛЭНГЭ АЙМАГ  
ЗҮҮНБҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 154

Жаргалант

Ой, хээрийн гал түймрээс  
хамгаалах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3. "а", 1.6 "а", Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.18, 17.2.20, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2017 оны "Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх тухай" А/70 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ус цаг уур орчны шинжилгээний газраас ирүүлсэн цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээллээр 3,4-р саруудад цасан бүрхүүл багатай, хуурайшилттай байх төлөвтэй тул багийн нутаг дэвсгэрийн хэмжээнд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ухуулга, сурталчилгаа хийж, гамшиг ослын үед байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулан хөдөлгөөнт эргүүлийн томилгоог тодотгон, түймрийн багаж хэрэгсэл бэлтгүүлэхийг багийн Засаг дарга Ч.Уранчимэг, С.Бат-эрдэнэ, Д.Чулуунбаатар нарт үүрэг болгосугай.

2. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар гаргасан захирамж шийдвэрийг хэрэгжүүлж, эзэмшил ойн сан бүхий газрыг хамгаалж ажиллахыг ойн нөхөрлөл, малчны бүлгүүдэд үүрэг болгосугай.

3. Ой, хээрийн түймэр гарах нөхцөл бүрдсэн хуурайшилтын хугацаа буюу 03 дугаар сарын 10-ны өдрөөс 6 дугаар сарын 10-ыг хүртэлх хугацаанд ойд мод бэлтгэх, ойн дагалт баялагийг ашиглах, ойд зугаалгаар явах, ан хийх болон бусад үйл ажиллагаа явуулахыг хязгаарлаж ААН-ийн захирал, байгууллагын дарга, эрхлэгч, иргэдэд сэрэмжлүүлж хяналт шалгалтыг өндөржүүлж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч О.Эрдэнчимэг, Байгаль хамгаалагч М.Нямдорж нарт үүрэг болгосугай.

4. Ой, хээрийн түймэр гарсан тохиолдолд эзэн холбогдогч, шалтгаан нөхцлийг тогтоон, эзэн холбогдогчдод хариуцлага тооцож ажиллахыг Хэсгийн төлөөлөгч, Цагдаа нарт үүрэг болгосугай.

5. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор дайчилгаанд эхний ээлжинд ажиллах 15 хүний бүрэлдэхүүнтэй шуурхай бүлгийн томилгоонд

0000121

нэмэлт тодотгол оруулахыг сумын Гамшгаас хамгаалах штабын дарга /Д.Гантулга /-д үүрэг болгосугай.

6. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, арга хэмжээ аваагүй болон түймрийн дайчилгаанаас зайлсхийсэн иргэн, аж ахуйн нэгжийн дарга, эрхлэгч нарт Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч О.Эрдэнэчимэгт үүрэг болгосугай.

ДАРГА



Х.БАДРАЛ